# “Дундговь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө шинэчлэх”

*Дундговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд зориулав.*

Бэлтгэсэн: Газрын мэргэжлийн байгууллага “Вектор мэп” ХХК

Мандалговь хот

2018-12-04

# ЕРӨНХИЙ ХЭСЭГ

Газар, байгалийн нөөцийг экологийн доройтолгүй ашиглах үндэсний хэмжээний бодлогыг Монгол улс тогтвортой хөгжлийн зорилтод үндэслэн экологид тулгуурласан нийгэм-эдийн засгийн хөгжлийн бодлогыг гаргасан байна. Үүнийг хэрэгжүүлэх нэг гол нөхцөл нь эдийн засгийн хөгжлийн бүсчлэлийн ерөнхий бүдүүвчтэй уялдсан салбарын хөгжлийн бодлогыг тодорхойлж, түүнд шаардлагатай газрын хэмжээ, байршлыг оновчтой тогтоож, газрыг урт хугацааны туршид экологийн болон эдийн засгийн хувьд үр ашигтай ашиглах явдал юм. Аймгийн түвшинд газрын харилцааны асуудлыг өнөөгийн нөхцөлд хэрэгжүүлэх механизм нь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө юм.

# Үндэслэл

- ✓ Газрын тухай хууль;
- ✓ Газрын кадастрын тухай хууль;
- ✓ Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх хууль;
- ✓ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- ✓ Тариалангийн тухай хууль;
- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- ✓ "Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал";
- ✓ "Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого";
- ✓ Төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөр;
- ✓ Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030;
- ✓ Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө;
- ✓ Барилга, хот байгуулалтын Сайдын 2007 оны 156-р тушаалаар баталсан "Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах арга зүйн заавар";
- ✓ "Шинэ бүтээн байгуулалт, дунд хугацааны зорилтот хөтөлбөр";
- ✓ "Монгол мал" хөтөлбөр";
- ✓ Газрын харилцаа геодези зурагзүйн газрын даргын 2013 оны А/97 дугаар тушаалаар батлагдсан "Газар өмчлөлийг эрчимжүүлэх чиглэл";
- ✓ Геодези, зурагзүйн ажлын жишиг үнэ /БД81-103-06/;
- ✓ Зураг төслийн ажлын жишиг үнэ /БД 81-16-12/;
- ✓ Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль хамгааллын салбаруудын дэд хөтөлбөр, төлөвлөгөө стратеги 2018-2028 он;
- ✓ Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого;
- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- ✓ Дундговь аймгийн 2012-2031 оны хөгжлийн төлөвлөгөө;
- ✓ Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг болно.

# “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-ний схем



## ЗОРИЛГО

Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн аймгийн хөгжлийн төлөвлөгөө, сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө болон салбар хоорондын хөгжлийн бодлоготой уялдуулан, байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай, нийгмийн хөгжлиййг дэмжиж, иргэд-олон нийтийн оролцоог хангасан тогтвортой газрын харилцааны баримт бичиг боловсруулахад оршино.

## ЗОРИЛТ

- *Аймгийн газар зохион байгуулалтын бодлогыг Улс, бүс, аймгийн салбаруудын хөгжлийн хөтөлбөр, сумдын хөгжлийн бодлоготой уялдуулах;*
- *Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд байгалийн нөхцөл, нөөц, газар ашиглалтын өнөөгийн байдлыг тодорхойлох;*
- *Иргэдийн газрын хэрэгцээт байдлыг судалж, газрын харилцаанд идэвхитэй оролцох нөхцөлийг бүрдүүлсэн, тогтвор суурьшилтай ажлын байр, хүртээмжтэй нийгмийн үйлчилгээ үзүүлэх, эрүүл аюулгүй орчинд амьдрах, нээлттэй газрын хуваарлалт бий болгох;*
- *Байгалийн болон газрын нөөц чадавхийн мэдээллийг шинэчлэн боловсруулж судалгааны үр дүнг нэгтгэн боловсруулсан тоон болон зурган мэдээллийн сан бүрдүүлэх,*
- *Газрын тохиромжтой байдлын үнэлгээнд суурилсан газрын харилцааны олон зориулалтыг хангахуйц газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах;*

| ЗОРИЛТ | | ҮЙЛ АЖИЛЛАГАА | |
|---|---|---|---|
| 1 | Аймгийн газар зохион байгуулалтын бодлогыг Улс, бүс, аймгийн салбаруудын хөгжлийн хөтөлбөр, сумдын хөгжлийн бодлоготой уялдуулах; | 1.1 | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөгөөнд тусгагдсан саналуудыг Дундговь аймгийн хэмжээнд тусгах |
| | | 1.2 | "ТӨВ" бүсийн хөгжлийн төлөвлөгөөний саналуудыг Дундговь аймгийн хэмжээнд тусгах |
| | | 1.3 | Дундговь аймгийн хөгжлийн бодлого, салбаруудын хөгжлийн бодлого төлөвлөгөөг тусгах |
| | | 1.4 | Дундговь аймгийн сум бүрийн /15 сум/ бодлого, хөтөлбөрийг тусгаж төлөвлөсөн баримт бичгүүдтэй уялдуулсан саналыг тусгах |
| 2 | Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд байгалийн нөхцөл, нөөц, газар ашиглалтын өнөөгийн байдлыг тодорхойлох; | 2.1 | Байгалийн нөхцөл, нөөцийн судалгаа хийх /уур амьсгал, хөрс, ургамал, инженер геологи, амьтан г.м/ |
| | | 2.2 | Газар ашиглалтын судалгаа хийх, өнөөгийн байдлыг тодорхойлох /ХАА, хот тосгон бусад суурин, зам, шугам сүлжээ, ой, ус, тусгай хэрэгцээ/ |
| 3 | Иргэдийн газрын хэрэгцээт байдлыг судалж, газрын харилцаанд идэвхитэй оролцох нөхцлийг бүрдүүлсэн, тогтвор суурьшилтай ажлын байр, хүртээмжтэй нийгмийн үйлчилгээ үзүүлэх, эрүүл аюулгүй орчинд амьдрах, нээлттэй газрын хуваарьлалт бий болгох; | 3.1 | Аймаг, сумын ЗДТГ, салбар байгууллагын мэргэжилтэн, иргэн, аж ахуй нэгжийн санал, бодол |
| | | 3.2 | Аймаг, сумын ЗДТГ, салбар байгууллага, зорилтод бүлгийн хэлэлцүүлэг хийх, багийн Иргэдийн Нийтийн Хурлын хэлэлцүүлэг, санал |
| | | 3.3 | Эрүүл мэнд, соёл, боловсрол, худалдаа үйлчилгээг хүртээмжтэй тогтвортой болгох, |
| | | 3.4 | Хөнгөн хүнсний үйлдвэрийг хөгжүүлэх, тогтвортой ажлын байр бий болгох, эдийн засгийн хөгжлийг хангах |
| | | 3.5 | Ногоон байгууламж, эрүүл хүнс, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлсэн нээлттэй, ил тод газрын хуваарьлалтыг төлөвлөх |
| 4 | Байгалийн болон газрын нөөц чадавхийн мэдээллийг шинэчлэн боловсруулах, нэгтгэх, тоон болон зурган мэдээллийн сан бүрдүүлэх, | 4.1 | Аймгийн байгалийн нөхцөл, нөөцийн мэдээллийг бүрдүүлж боловсруулсан мэдээллийн сан бүрдүүлэх |
| | | 4.2 | Аймгийн газар ашиглалтын өнөөгийн байдал болон төлөвлөгөөний мэдээллийн сан бүрдүүлэх |
| 5 | Газрын тохиромжтой байдлын үнэлгээнд суурилсан газрын харилцааны олон зориулалтыг хангахуйц газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах; | 5.1 | Аймгийн газар ашиглалтын төлөвлөлтийн хориглон хамгаалах бүсийн төлөвлөгөө боловсруулах |
| | | 5.2 | Аймгийн газар ашиглалт бүрээр тохиромжтой байдлын үнэлгээ хийх, төлөвлөгөө боловсруулах |
| | | 5.3 | Аймгийн ХАА-н газрын төлөвлөгөө |
| | | 5.4 | Аймгийн Хот тосгон бусад суурин газрын төлөвлөгөө |
| | | 5.5 | Аймгийн Зам, шугам сүлжээний газрын төлөвлөгөө |
| | | 5.6 | Аймгийн Ойн сангийн газрын төлөвлөгөө |
| | | 5.7 | Аймгийн Усны сангийн газрын төлөвлөгөө |
| | | 5.8 | Аймгийн Тусгай хэрэгцээний газрын төлөвлөгөө |

# Үе шат

- Бэлтгэл үе шат
- Хээрийн хэмжилт, судалгаа
- Материал боловсруулалт хийх, төлөвлөгөөний төсөл бэлтгэх
- Сум, Багийн ИНХурлаар хэлэлцүүлэх, санал авах,
- Аймгийн ГЗБЕТөлөвлөгөөний төслийг бэлтгэх, мэргэжлийн байгууллагаар хянуулах
- Аймгийн ИТХурлаар хэлэлцүүлэх, санал авах, батлуулах
- Аймгийн ГЗБЕТөлөвлөгөөг эцэслэн боловсруулж холбогдох байгуулагуудад хүлээлгэн өгөх

Схем 1. Бэлтгэл ажлын үе шат



# Хээрийн хэмжилт, судалгаа

- Танилцуулах уулзалт, хэлэлцүүлэг, санал асуулга авах
- Статистик мэдээлэл цуглуулах
- Газар дээрх хэмжилт бүртгэл, заагийг тогтоох
- Газар ашиглалтын өнөөгийн байдлыг тодорхойлох

*Хээрийн хэмжилт судалгааны ажлыг 2018 оны 07 дугаар сарын 17-ны өдрөөс 08 дугаар сарын 10-ны хооронд 2 ажлын хэсэг гарган гүйцэтгэсэн бөгөөд ажлын зохион байгуулалт хяналтыг Дундговь аймгийн ГХБХБГазар давхар гүйцэтгэж, 2 ажлын хэсэгт хуваагдан ажилласан.*



# *Танилцуулах уулзалт, ярилцлага /аймагт/*

Дундговь аймгийн ЗДТГазрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, ХХААГ, БОАЖГ, ГХБХБГ-ын дарга болон холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, танилцуулга хийж, аймгийн хөгжлийн бодлогын талаар чиглэл, салбаруудын уялдаа холбоог хангах, аймгийн ГЗБЕТ-д тусгах санал солилцон хамтран ажилласан.






ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
48090 Сайнцагаан сум, Дундговь аймаг,
Утас: 7059-2494, Факс: 7059-2896,
E-mail: info@dundgovi.gov.mn

2018.07.19 № 4/816

танай ____________ -ны № ____________ -т

"ВЕКТОР МЭП" ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Ш.НАРАН-ОЧИР ТАНАА

Санал, мэдээлэл хүргүүлэх тухай

Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай материалуудыг хүргүүлж байна. Мөн дараах асуудлуудыг ГЗБЕТ-нд тусгуулах саналтай байна.

Үүнд:

1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-т заасны дагуу бүх сумдын түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын талбайг тусгах, төлөвлөх
2. Аймгийн ИТХТ-ээр баталсан ашигт малтмалын тээвэрлэлтийн маршрутыг тусгах
3. Ашигт малтмалын ашиглалтын (уурхайн) талбайг төлөвлөн оруулах
4. Уул уурхайн улмаас нөхөн сэргээгдэлгүй орхигдсон, эвдэрсэн газрыг тусгах
5. Улс, аймаг, сумдын тусгай хамгаалалттай (тусгай хэрэгцээний) газар нутгийн талуудын зөрүүтэй мэдээллийг нэгтгэн тусгах
6. Аймаг, сумдаас гарсан бодлогын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах

Дээрх саналуудтай холбогдуулан аймаг, сумдын нутагт бүртгэлтэй тусгай зөвшөөрлийн бүртгэл, "Дундговь аймгийн Нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр 2018-2028", Ашигт малтмал тээвэрлэх замын маршрут, Тусгай хамгаалалттай газар нутгийн жагсаалт, Түгээмэл тархацтай ашигт малтмалын жагсаалт, "Дундговь аймгийн аялал жуулчлалын салбарын Хөгжлийн стратеги төлөвлөгөө - 2012-2018 он" зэргийг файл хэлбэрээр цахимаар хүргүүллээ.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Н.ЭРДЭНЭ-ОЧИР

ТУС0068 Я 9033548

0330197

*Танилцуулах уулзалт, ярилцлага /сумдад/*

Дундговь аймгийн 15 сумын хэмжээнд танилцуулга хийж, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Үүнд: Сумын Засаг дарга, Орлогч дарга, Багийн засаг дарга нар, Санхүүгийн албаны дарга, ХАА-н бэлчээрийн усан хангамж, газрын даамал, байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч, цаг уурын мэргэжилтэн, мал үржлийн тасгийн мэргэжилтэн /малын эмч/ болон сумын холбогдох мэргэжилтнүүд, сумын төвийн иргэд, малчид г.м









## *Хэлэлцүүлэг "Багийн Иргэдийн Нийтийн Хурал"*

Сумдын багуудийн хурлыг 10-р сарын 15-27 хүртлэх хугцаанд 14 сумын багийн хурлыг зохион байгуулж санал хэлэлцүүллээ. Дараах асуудлуудыг хэлэлцүүлж албажуулсан. Үүнд:

1. *Баг хоорондын заагийг тодорхойлох, зурагжуулах*
2. *Хөдөө аж ахуйн газрын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний санал, хэлэлцүүлэг*
   a. *Сум болон багийн хадлангийн газар төлөвлөгөө*
   b. *Малчдын бэлчээрийн улирлын хувиарын төлөвлөгөө*
   c. *Отор болон алслагдсан, ашиглалтгүй бэлчээрийг ашиглах төлөвлөгөө*
   d. *Төмс хүнсний ногоо, үр тариа, жимс жимсгэнэ тариалах газрын төлөвлөгөө*
   e. *Усжуулах шаардлагатай бэлчээр нутаг болон хөв цөөрөм байгуулах газрын төлөвлөгөө*
   f. *Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн газрын төлөвлөгөө*
3. *Хот тосгон, бусад суурины газрын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний санал, хэлэлцүүлэг*
   a. *Одоогийн суурин газар тэлэх, шинээр суурин газар үүсгэх газрын төлөвлөгөө*
   b. *Зарим багийн төвүүдийг суурин газар болгох төлөвлөгөө*
   c. *Аялал жуулчлал, амралт сувилалын зориулалтаар олгох газрын төлөвлөгөө*
4. *Эрчимжсэн аж ахуйн бүсийг тогтоох, төлөвлөх /үүлдэр-мах, сүү; гахай, тахианы аж ахуй, засварлах болон шинээр байгуулах боломжтой зам, цахилгаан болон холбоо харилцааны шугам сүлжээний газрын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний санал, хэлэлцүүлэг*
5. *Ойн газрын ашиглалт хамгаалалтын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний санал, хэлэлцүүлэг*
6. *Тусгай хэрэгцээний газрын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний санал, хэлэлцүүлэг*
7. *Зүй ёсны эрхийг бүртгэн баталгаажуулах саналыг хэлэлцүүлэг*

   *А.Бэлчээрийг гэрээгээр ашиглах*

   *Б. Байгалийн нөөцийг ашиглах, хамгаалах г.м*

*Хэлэлцүүлэг "Багийн Иргэдийн Нийтийн Хурал"*










## *Хэлэлцүүлэг “Аймгийн нэгдсэн хэлэлцүүлэг”*

2018-11-29-ны өдөр Аймгийн Газрын харилцаа, Барилга, хот байгуулалтын газартай хамтран зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт Аймгийн ИТХ-ын дарга С.Сүхбаатар, Аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ, Аймгийн Засаг даргын орлогч Ж.Мөнхчулуун, аймгийн ИТХ-ын зарим төлөөлөгч, ГЗБГЗЗГ-ын дарга Ц.Ганхүү, ГЗБГЗЗГ-ын Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Ж.Батсайхан, мэргэжилтэн С.Дэнсмаа, Аймгийн ЗДТГ-ын ХОХБХэлтсийн дарга Н.Эрдэнэ-Очир, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, Газрын даамлууд , Мал эмнэлгийн үржлийн тасгийн дарга нар, Бэлчээр ашиглагчдын хэсгийн малчдын төлөөлөл бүхий нийт 89 төлөөлөгч оролцож аймгийн ГЗБЕТ-ний ангилал тус бүрээр хэлэлцэн саналаа өгч хэлэлцүүлж ажиллаа.




ДУНДГОВЬ АЙМАГ

ДУНДГОВЬ АЙМАГ

ДУНДГОВЬ АЙМАГ


## ***Санал, хэлэлцүүлэг***

- Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий болон сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад нутгийн иргэдийн оролцоо хамгаас чухал. Төлөвлөгөө боловсруулахдаа иргэдийн оролцоог хангаж орон нутгийн хэрэгцээт байдлын үнэлгээг гаргах үүднээс малчин, тариалан эрхлэгчид, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид, мөн зорилтод бүлгийг судалгаанд хамруулсан болно.
- 15 сумын хэмжээнд нийгэм-эдийн засаг, байгалийн нөөц, баялагийн ашиглалт, газар ашиглалттай холбоотой ярилцлага, хэлэлцүүлэг, санал асуулга, багийн Иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулж төрийн байгууллага, иргэд, хуулийн этгээдийн оролцоог хангаж хамтран ажиллаа.
- Иргэдийн саналыг төлөвлөгөөнд тусгах чиглэлээр түүвэрлэх аргаар судалгаа явууллаа. Судалгаанд нийт аймгийн удирдлага болон салбар байгууллагуудын санал 104, сумын төрийн албан хаагч 187, малчин өрх 910, төв суурин газрын иргэд 356, тариалан эрхлэгч 26, аж ахуй нэгж байгууллагын төлөөлөл 157 тус тус хамруулсан ба нийт 1636 санлын хуудас бөглүүлж, 1201 иргэн хэлэлцүүлэгт оролцсон байна.

# *Сумын статистик мэдээ цуглуулах*

Хүн амын тоо 2017 оны дүнгээр 46383 хүн амтай. үүнээс эрэгтэй 23305, эмэгтэй 23078 байгаа бөгөөд аймагт 23072 иргэн, хөдөөд 23341 иргэн бүртгэлтэй байна.




Малын тоо аймгийн дүн нийт 3592978 тоо толгой, үүнээс: адуу 160153, үхэр 75277, тэмээ 36792, хонь 1686203, ямаа 1634553 тус тус байна.






## ӨРХИЙН СУДАЛГАА

| Он | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 |
|---|---|---|---|---|---|
| Өрхийн тоо | 13017 | 13234 | 13092 | 13183 | 13186 |
| Өсөлтийн хувь | | 1.7 | -1.1 | 0.7 | 0.02 |
| Он | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
| Өрхийн тоо | 13282 | 13438 | 13900 | 14128 | 14556 |
| Өсөлтийн хувь | 0.7 | 1.2 | 3.4 | 1.6 | 3.0 |




## БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН СУДАЛГАА

| Засаг захиргааны нэгж | Аж ахуйн нэгж, байгууллага | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дундговь аймаг | Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй | 10 | 10 | 12 | 18 | 17 | 24 | 22 | 22 | 23 | 24 |
| | Уул уурхай, олборлох аж үйлдвэр | 1 | 1 | 1 | 2 | 4 | 4 | 6 | 6 | 6 | 6 |
| | Боловсруулах үйлдвэр | 23 | 23 | 25 | 38 | 36 | 20 | 39 | 40 | 38 | 36 |
| | Цахилгаан, хий үйлдвэрлэл, ус хангамж | 3 | 3 | 2 | 3 | 4 | 2 | 3 | 2 | 2 | 2 |
| | Барилга | 3 | 3 | 5 | 7 | 9 | 9 | 15 | 14 | 14 | 16 |
| | Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоцикл, түлш, шатахууны худалдаа, засвар үйлчилгээ | 125 | 126 | 134 | 135 | 155 | 181 | 166 | 187 | 200 | 208 |
| | Зочид буудал, зоогийн газар | 15 | 16 | 13 | 17 | 20 | 22 | 25 | 28 | 28 | 32 |
| | Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо | 12 | 12 | 11 | 9 | 11 | 11 | 12 | 13 | 12 | 15 |
| | Санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа | 9 | 11 | 6 | 21 | 25 | 14 | 12 | 12 | 11 | 15 |
| | Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа | 12 | 17 | 11 | 21 | 20 | 19 | 25 | 29 | 28 | 26 |
| | Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа | 51 | 51 | 53 | 47 | 46 | 48 | 48 | 48 | 48 | 49 |
| | Боловсролын салбарын үйл ажиллагаа | 36 | 36 | 35 | 55 | 46 | 48 | 49 | 48 | 47 | 47 |
| | Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа | 55 | 56 | 58 | 48 | 49 | 54 | 57 | 62 | 63 | 68 |
| | Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ | 47 | 47 | 35 | 66 | 51 | 57 | 54 | 74 | 81 | 95 |
| | Олон улсын байгууллагын үйл ажиллагаа | 0 | 0 | 0 | 0 | 0 | | | | | 0 |
| | Нийт | 402 | 412 | 401 | 487 | 493 | 513 | 533 | 585 | 601 | 639 |

| Засаг захиргааны нэгж | Өмчийн хэлбэр | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дундговь аймаг | Төрийн өмчийн | 138 | 138 | 139 | 98 | 98 | 101 | 104 | 106 | 108 | 108 |
| | Төрийн өмчийн оролцоотой | 0 | 0 | 0 | 0 | 0 | | | | | 0 |
| | Төрийн өмчийн хамтарсан | 0 | 0 | 0 | 0 | 0 | | | | | 0 |
| | Хувийн | 242 | 252 | 240 | 336 | 341 | 362 | 376 | 425 | 439 | 476 |
| | Хувийн хамтарсан | 1 | 1 | 1 | 0 | 0 | | 1 | | | 0 |
| | Гадаад улсын | 2 | 2 | 2 | 1 | 1 | 1 | 1 | 2 | 2 | 2 |
| | Орон нутгийн өмчийн | 19 | 19 | 19 | 52 | 53 | 49 | 51 | 52 | 52 | 53 |
| | Нийт | 402 | 412 | 401 | 487 | 493 | 513 | 533 | 585 | 601 | 639 |

# Газар ашиглалтын өнөөгийн байдал түүний хил зааг, байршил тогтоож зураглах



## АЖЛЫН ЗУРАГ




ХУЛД СУМЫН 3-Р БАГ УУЛ БАГИЙН ГАЗАР АШИГЛАЛТЫН ЗУРАГ


ГУРВАНСАЙХАН СУМЫН 3-Р БАГ ЧУЛУУТ БАГИЙН ГАЗАР АШИГЛАЛТЫН ЗУРАГ











*Хээрийн хэмжилт, тодруулалтын зарим фото зургаас*

**Бэлтгэл болон хээрийн судалгаа**
**/ Суурь судалгаа/**

| | |
|---|---|
| Байгалийн нөөц, төрх байдлын судалгаа | • Уур амьсгал /агаарын температур, хур тунадас, шороон болон цасан шуургатай өдрийн тоо/<br>• Газрын гадарга /налуу, зүг зовхис, өндөржилт/<br>• Байгалийн нөөцийн үзүүлэлт /хөрс, ургамал, ой, гадаргын болон гүний усны нөөц/ |
| Нийгэм, эдийн засгийн судалгаа | • Хүн амын судалгаа /тоо, нас хүйсний бүтэц/<br>• Малын судалгаа /тоо, төрөл, бүтэц, даац/<br>• Аж ахуйн үйл ажиллагааны төрөл, чиглэл<br>• Түүх соёлын дурсгал |
| Газар ашиглалтын судалгаа | • Бэлчээрийн газрын ашиглалт<br>• Хадлангийн газрын ашиглалт<br>• Суурин газрын ашиглалт<br>• Зам шугам сүлжээний газрын ашиглалт<br>• Ойн сан бүхий газрын ашиглалт<br>• Уурхайн ашиглалт /ашиглалтын болон хайгуулын лицензтэй талбай /<br>• Тусгай хамгаалалттай газрын ашиглалт |
| Бодлогын бичиг баримтын судалгаа | • Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал,<br>• Төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөр,<br>• Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030<br>• Аймгийн бүсчилсэн хөгжлийн бодлого<br>• Сумдын бодлого хөтөлбөрүүд |

# Мэдээллийн сан

- Дундговь аймгийн хэмжээнд өмнө хийгдсэн сууpь судалгаа, судлагдсан байдлын мэдээллүүдийг холбогдох байгууллагуудаас зохих журмын дагуу цуглуулж Монгол улсын хууль, эрх зүйн орчинд нийцүүлэн ажиллаа.
- Дундговь аймгийн хэмжээнд газар байгалийн нөхцөл нөөц, нийгэм эдийн засаг, газар ашиглалтын судалгааг 2018 оны байдлаар 1:100 000 масштабын нарийвчлалтайгаар зурагжуулан судалгаа хийсэн ба тус тайланд орсон мэдээлэл бүрийг орон нутаг сум бүрээс бүрдүүлж судлан ажилсан.
- Мэдээллийн үнэн бодит байдлыг хангах үүднээс өндөр нарийвчлалтай сансарын зураг, сүүлийн жилд хийсэн хэмжилт зураглалын мэдээллийг ашигласны зэрэгцээ хээрийн хэмжилт тодруулалтын ажлаар нэг бүрчлэн тулгалт хийж мэдээллийг чанаржуулан ажиллаа.
- Дээрх тоон мэдээллүүдийг Засгийн газрын 2009 оны 25-р тогтоолоор батлагдсан “WGS-84 солбицол, өндрийн сүлжээг Балтийн тэнгисийн өндрийн тогтолцоонд тулгуурлан, тоон мэдээний боловсруулалт хийж нэгдсэн нэг UTM тусгалд оруулллаа.
- Аймгийн хэмжээнд байгалийн нөхцөл, нөөц, газрын гадарга болон газар доорх судалгаа, газар ашиглалтын өнөөгийн байдлыг 2018 оноор тодорхойлж мэдээллийн сангийн программ хангамж (ArcGIS, Erdas imagine, Quantum GIS, Land manager) дээр суурилсан боловсруулалт хийж мэдээллийн сантай (Geodatabase) болсон.



## *Газрын гадаргын судалгаа*

- Дундговь аймгийн газрын гадарга 1201-1500 метрийн дундаж өндөржилттэй, нийт газар нутгийн 28.1 хув нь 1301-1400 м, 23 хувь нь 1201-1300 м, 18,6 хувь нь 1401-1500 м, 15,8 хувь нь 1101-1200 м, 9.3 хувь нь 1001-1100 м, 4.5 хувь нь 1501-1600 м-ийн өндөржилттэй тогтсон байна.

- Аймгийн хэмжээнд гадаргын налуу нь 0.0-3.0 градусын хэвгий бүхий газар 5520560.88 га буюу 73.9 хувь, 3.1-5.0 градусын хэвгий бүхий газар 1542074.08 га буюу 20.6 хувь, 5.1-10.0 градусын хэвгий бүхий газар 381923.7 буюу 5.1 хувь, 10.1-12.0 градусын хэвгий бүхий газар 10997.7 га буюу 0.1 хувь, 12.1-ээс дээш грасдусын хэвгий бүхий газар 13763.5 га буюу 0.2 хувь тус тус байна. Хот суурин байгуулах, зам шугам сүлжээ татах, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд тохиромжтой 0-5 градус хэвгий бүхий газар 94.5 хувийг эзэлж байна.












## Газрын хөрсний судалгаа

Дундговь аймгийн нутгийн хөрсөн бүрхэвч уулын хөрс, /уулын хүрэн, цайвар хүрэн, бор/, уулсын хоорондох хөндийн нугын хужир, мараалаг карбонатлаг, алювийн нугын, уулсын хооронд хөндийн хүрэн ба цайвар хүрэн, цөлөрхөг хээрийн бор, элсэн хужаастай болон хад цохио гэсэн хэв шинжид хуваагдаж байна. Хөрсний механик бүрэлдэхүүний хувьд 71 хувь буюу 5303482.5 га талбайг элсэнцэр хөрс, 23.7 хувь буюу 1772011.6 га талбайг хөнгөн шавранцар хөрс, 2.5 хувь буюу 186239.3 га талбайг хүнд шавранцар хөрс, 1.5 хувь буюу 114021.1 га талбайг дунд шавранцар хөрс, 1.2 хувь буюу 93265.2 га талбайг элс тус тус эзэлдэг байна.






<u>**Бэлчээрийн газрын судалгаа**</u>

Ургамалжилтын бүс, бүслүүрийн хээр болон цөлөрхөг хээрийн бүсэд хамаардаг. Бэлчээрийн экологийн нөхцөлийн хувьд хамгийн өргөн тархалттай нь уулын хээрийн бэлчээр 2059.1 мян.га буюу 27.9%, тал хээрийн бэлчээр 1181.6 га буюу 16 %, нам хотосын болон цөлийн бэлчээр 6.1-9.2%-ийг эзэлж байна. Ургамалжилтын төрлөөр ангилахад хамгийн их нь уулын цайвар хүрэн ба бор хөрстэй цөлөрхөг хээрийн Монгол өвс-хазаар өвст, Хазаар өвс-монгол өвст бэлчээр 6.4 хувийг эзэлж байгаа нийт 99 төрлийн бэлчээрийн ургамалжилт тархсан байна.

Бэлчээрийн төрх байдлын хувьд сөөгтэй 1681.4 мян.га, чулуутай 2426.9 мян.га, дов сондуултай 539.3 мян.га, цэвэр өвслөг ургамалтай 2729.9 мян.га бэлчээр тус тус эзэлж байна. Бэлчээрийн төлөв байдал нь автогений нөлөөлөлд 44 мян.га, элсжсэн 88.4 мян.га, усны эвдрэлд өртсөн 16.3 мян.га, оготно царааны нүүдэлд өртсөн 2 560 мян.га, хүний үйл ажиллагааны шууд нөлөөгөөр элэгдэл эвдрэлд орсон 609,4 га газарт өөрчлөлт орсон байна.









## Бэлчээрийн газрын ашиглалтын өнөөгийн байдал

Аймгийн хэмжээнд нийт 5814 хөвөлжөө хаваржаа, зуслан намаржааны доорхи газар байна. үүнээс өвөлжөө 1061, хаваржаа 906, өвөлжөө-хаваржаа 376, дөрвөн улирал нутагладаг 2628 доорхи газар байна.

Уст цэгийн тоо инженерийн хийцтэй худаг 715, гар худаг 3398, булаг 202, гол 1, нуур тойром 427 тус тус бүртгэгдсэн байна.

Бэлчээрийн даац нь 2018 оын байдлаар аймгийн дундаж 2,5 дахин хэтрэлттэй байана. Сайнцагаан сум 5 дахин, Адаацаг сум 4 дахин, Эрдэнэдалай сум 3.3 дахин, Дэлгэрцогт сум 3,2 дахин хэтэрсэн бол Өлзийт сум хэтрээгүй байна. Энэ нь мал сүргийн тоо сүүлийн жилүүдэд огцом өссөн бэлчээрийн ургац буурсантай холбоотой юм.









## Ус ашиглалт

Гадаргын усны хувьд умард говийн гүвээт-Халхын дундат талын сав газарт баруун хэсэг нь Онги голын сав газарт багтана. Аймгийн хэмжээнд 2018 оны байдлаар байнгын урсгалтай гол 1 /Онгийн гол/, булаг шанд 202, нуур тойром 427, инженерийн хийцтэй худаг 715, гар худаг 3398 тус тус байна.









## Газрын төлөв, байдал




Автогений нөлөөнд орсон 44 мян.га байгаа нь нийт бэлчээрийн 0.6 хувьтай тэнцэж байна. Эрдэнэдалай, Дэлгэрхангай, Өлзийт сумдын нутагт 88.4 мян.га элсний нүүдэлтэнд өртөж Дэлгэрцогт, Сайнцагаан, Луус, Хулд сумдын 16.3 мян.га бэлчээр усны эвдрэлтэй байна. Адаацаг Баянжаргалан, Дэлгэрцогт, Дэрэн, Сайнцагаан сумдын нутагт үлийн цагаан оготно, царцаа болон нугын бор эрвээхэй элбэгших хандлагатай байв.

Дундговь аймагт уул, уурхайн олборлолт болон ашиглалт болон хүний буруутай үйл ажиллагааны улмаас эвдэрч, сүйтсэн газрын тооллого хийх, зурагжуулах, талбайн хэмжээг тодорхойлох ажлыг 2018 оны 5-р сард хийж гүйцэтгэсэн. Уг эвдэрсэн газрын тооллогоос үзэхэд тус аймгийн нийт 15 сумын 609.6 га талбай уул уурхайн олборлолт болон бусад шалтгааны улмаас эвдэрч сүйтсэн байна.






## Зам, шугам, сүлжээний газар ашиглалт

Зам, шугам сүлжээний ангиллын газар 53.2 мян.га талбай байна. Үүнээс авто замын газар 48.0 мян.га буюу 90.1 хувь, төмөр замын газар 238.6 га буюу 0.4 хувь, агаарын тээврийн газар 77.9 га буюу 0.1 хувь, шугам сүлжээний газар 5.0 мян.га буюу 9.3 хувь тус тус эзэлж байна.

## Ойн газар ашиглалт

| Ангилал | Дэд ангилал | Ойн газрын хэмжээ /га/ | Ойн сангийн газар /га/ | Тусгай хамгаалалттай газрын ой /га/ |
|---|---|---|---|---|
| Ой модоор бүрхэгдсэн газар | Заган ойгоор бүрхэгдсэн | 34905.9 | 16882.9 | 18023.0 |
| | Мод үржүүлгийн газар | 42.3 | 42.3 | 0.0 |
| Ой модоор бүрхэгдээгүй газар | Ойн цоорхой | 224.0 | 200.6 | 23.4 |
| | Ой тэлэн ургах нөөц газар | 8301.8 | 3562.2 | 4739.5 |
| Нийт | | 43473.9 | 20688.0 | 22785.9 |




Дундговь аймгийн өмнөд хэсэг буюу Өлзийт суманд ойн сан бүхий газартай ба Шорвогийн хоолой, Загийн усны хөндий, Замын сүүжийн хоолой, Өөшийн элс орчимд нийт таван байрлалд ойн сангийн 16882.9 га га талбайд заган ой тархан ургасан байна.

## *Тусгай хэрэгцээний газар*




Аймгийн улсын тусгай хэрэгцээний 425730.6 га газар байна. Үүнд улсын тусгай хамгаалалттай газар 425682.1 га, Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар 46.9 га, Шинжлэх ухаан, технологийн сорилт туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай 1.6 га эзэлж байна.




Уул уурхай: 2018 оны 11-р сарын мэдээгээр тус аймагт нийт 214 байршлын 737237,36 га талбай бүхий тусгай зөвшөөрөлтэй газар бүртгэгдсэн байна. Үүний 121 байршилд 628439,3га газар хайгуулын тусгай зөвшөөрөлтэй, 93 байршилд 138798,04 га газар ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай байна.

## *Аялал жуулчлал*

Адаацаг, Гурвансайхан, Дэлгэрцогт, Өзийт, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Сайнцагаан зэрэг сумдад байгалийн үзэсгэлэнт, түүх соёлын дурсгалт, ховор ан амьтан бүхий газруудыг түшиглэсэн жуулчны бааз 16, амралт, сувилалын газар 8, ангийн отог 1 нийт 25 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.







Аймгийн хэмжээнд байгалийн үзэсгэлэнт газар 1, түүх соёлын үл хөдлөх дурсгал 2, тахилгат газар 16, эртний хот, суурин, сүмийн туурь 29, хөшөө дурсгал 34, булш, хиргисүүр, оршуулга 140, хадны сүг зураг, бичээс 30, түүрэн дурсгалт газар 1, чулуун зэвсгийн олдворт газар 1 тус тус байна.

## *Газрын нэгдмэл сан /2018 оны байдлаар/*

Дундговь аймгийн газар нутгийн хэмжээнд 7469019.6 га газар нутагтай, 2017 оны газрын нэгдмэл сангийн нийт талбайгаас 12.4 га талбайгаар бага байна. 2017 оны газрын нэгдмэл сангийн тайланг 2018 оны газрын нэгдмэл сангийн тооллоготой харьцуулахад хөдөө аж ахуйн газрын талбайгаас 345463.4 га, ойн сан бүхий газраас 48031.6 га газар тус тус хасагдсан бол хот тосгон бусад суурины газар 147744.4 га-гаар, зам шугам сүлжээний газар 21816.2 га-гаар, усны сан бүхий газар 23310.2 га-гаар, улсын тусгай хэрэгцээний газар 200611.8 га-гаар тус тус нэмэгдсэн байна.  Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 3 хувийг буюу 225118.83 га газар улсын тусгай хэрэгцээнд авсан байна.

| Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал | Хөдөө аж ахуйн газар | Хот тосгон бусад суурин газар | Зам шугам сүлжээний газар | Ойн сан бүхий газар | Усны сан бүхий газар | Улсын тусгай хэрэгцээний газар | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2017 оны тооллого | 7117568.2 | 18563.6 | 31265.7 | 68719.6 | 7796 | 225118.8 | 7469032 |
| 2018 оны тооллого | 6772104.8 | 166308 | 53081.9 | 20688 | 31106.2 | 425730.6 | 7469019.6 |
| Зөрүү | -345463.4 | 147744.4 | 21816.2 | -48031.6 | 23310.2 | 200611.8 | -12.4 |

# Газрын нэгдмэл сангийн зураг /2018 оны байдлаар/



# АЙМГИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

# НЭГ. ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

1. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал

2. Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого

3. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө

4. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал

5. Дундговь аймгийн хөгжлийн бодлого стратеги төлөвлөгөө 2012-2031 он

6. Дундговь аймгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө стратеги 2018-2028

7.Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөр

8. Хүнсний ногоо дэд хөтөлбөр

9. Аялал жуулчлалын салбарын стратеги төлөвлөгөө 2012-2018

10. Дундговь аймгийн сумдуудын хөгжлийн хөтөлбөр

## Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө









- **Хөдөө аж ахуйн газар**
- Услжуулах бэлчээр -Сайхан-Овоо
- Эрчимжсан мал аж ахуйн хөгжүүлэх болон тариалангийн бүс нутаг (Сайнцагаан, Сайхан-Овоо, Луус, Дэлгэрцогт, Дэрэн, Адаацаг)
- Хадлангийн хадах боломжтой газар (Адаацаг, Эрдэнэдалай)
- **Хот, тосгон бусад суурины газар**
- Аялал жуулчлал
    - Эмчилгээний аялал рекраци (Хулд бүлээний рашаан, Адаацаг сүм хөх бүрд, Өлзийт Өөшийн элс)
    - Олзвор, ангийн аялалын рекраци (Гурвансайхан, Дэлгэрхангай)
- Уул уурхай
    - Тусгай зөвшөөрөл цуцлах
    - Улсын төсвийн хөрөнгөөр геологийн хайгуул, зураглал хийх
    - Хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хориглосон газар

**Усны сан бүхий газар**

- Хөв цөөрөм байгуулах газар
- Хамгаалалтанд авах усны нөөцийн тэжээгдлийн муж
- Ойн сан бүхий газар
- Ойжуулалт хийх газрууд
- Зам шугам сүлжээний газар
- Мандалговь-Их газрын чулуу жуулчны бааз-Хөөтийн хонхорын нүүрсний уурхай-Өндөршил-Сайншанд

# Улсын тусгай хамгаалалтай газар

| № | Газрын нэр | Тусгай хамгаалалттай газрын ангилал | Харъяалагдах сум | Талбайн хэмжээ /га/ |
|---|---|---|---|---|
| **Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд** | | | | |
| 1 | Замын сүүжийн хоолой | Байгалийн нөөцийн газар | Өлзийт | 16751.8 |
| 2 | Зүүн жирмийн нуур | Байгалийн нөөцийн газар | Сайнцагаан | 2860.6 |
| 3 | Их нарт | Байгалийн нөөцийн газрын өргөтгөл | Өндөршил, Баянжаргалан | 31882.4 |
| 4 | Цагаан цав-хорхойтын хөндий байгалийн нөөцийн газар | Байгалийн нөөцийн газар | Дэлгэрхангай, Хулд | 110894.5 |
| 5 | Аргийн чулуу | Дурсгалт газар | Баянжаргалан | 948.8 |
| 6 | Модот | Дурсгалт газар | Эрдэнэдалай | 858.8 |
| 7 | Сүм хөх бүрд | Дурсгалт газар | Адаацаг | 993.8 |
| 8 | Цагаан суварга-цагаан дэл | Дурсгалт газар | Өлзийт | 1686.7 |
| 9 | Ширээ уул | Дурсгалт газар | Дэлгэрхангай | 1754.1 |
| **Нийт талбай** | | | | 168631.6 |

## ХОЁР. ГАЗАР АШИГЛАЛТЫН ТОХИРОМЖТОЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

1. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ
2. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ
3. Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээ
4. Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ
5. Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ
6. Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ
7. Усан сан, хөв цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын үнэлгээ
8. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

## *Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ*

| Д/д | Үнэлгээ | Талбай, га | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Бусад газар ашиглалт | 603353.2 | 8.1 |
| 2 | Тохиромжгүй | 1214811.6 | 16.3 |
| 3 | Хязгаарлагдмал тохиромжтой | 4575031.4 | 61.3 |
| 4 | Тохиромжтой | 1075823.4 | 14.4 |
| Нийт талбай | | 7469019.6 | 100 |







## *Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ*

| Д/д | Үнэлгээ | Талбай, га | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Бусад газар ашиглалт | 617222.4 | 8.3 |
| 2 | Нэн тохиромжгүй | 49052.3 | 0.7 |
| 3 | Тохиромжгүй | 1874466.0 | 25.1 |
| 4 | Хязгаарлагдмал тохиромжтой | 4665284.8 | 62.5 |
| 5 | Тохиромжтой | 233599.9 | 3.1 |
| 6 | Нэн тохиромжтой | 29394.5 | 0.4 |
| Нийт талбай | | 7469019.9 | 100.0 |

## Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээ

| Д/д | Үнэлгээ | Талбай. га | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Бусад газар ашиглалт | 132120.1 | 1.77 |
| 2 | Тохиромжгүй | 1628.2 | 0.02 |
| 3 | Хязгаарлагдмал тохиромжтой | 2017344.3 | 27.01 |
| 4 | Тохиромжтой | 5317927.4 | 71.2 |
| Нийт талбай | | 7469019.9 | 100 |







## Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ

| Д/д | Үнэлгээ | Талбай, га | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Бусад газар ашиглалт | 5979693.6 | 80.1 |
| 2 | Хадгалан хамгаалахад тохиромжтой газар | 1489326 | 19.9 |
| Нийт талбай | | 7469019.6 | 100.0 |

## Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

| Д/д | Үнэлгээ | Талбай, га | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Бусад газар ашиглалт | 132134.1 | 1.8 |
| 2 | Тохиромжгүй | 7095262.7 | 95.0 |
| 3 | Хязгаарлагдмал тохиромжтой | 241622.8 | 3.2 |
| Нийт талбай | | 7469019.5 | 100.0 |







## Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ

| Д/д | Үнэлгээ | Талбай, га | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Нэн хүндрэлтэй | 202023.9 | 2,7 |
| 2 | Хүндрэлтэй | 1885783.3 | 25,2 |
| 3 | Хэвийн | 5381212.7 | 72,0 |
| Нийт талбай | | 7469019,9 | 100,0 |

## *Усан сан, хөв цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын үнэлгээ*




| Таниур | Үнэлгээ | Талбай /га/ | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| | Тохиромжгүй | 48190.0 | 67.36 |
| | Дунд зэрэг тохиромжтой | 23351.4 | 32.64 |
| | **Нийт** | **71541.4** | **100** |

# Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

| № | Өвөл-хавар | Талбай. га | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Тэмээ | Адуу | Үхэр | Хонь | Ямаа |
| 1 | Бусад газар ашиглалт | 128639.1 | 128585.1 | 128638 | 128493.8 | 128493.8 |
| 2 | Нэн тохиромжгүй | 6553.7 | 173702.9 | 2776270.1 | 23400.9 | 23400.9 |
| 3 | Тохиромжгүй | 1068284.9 | 2851483.4 | 3463082.8 | 752038.9 | 752038.9 |
| 4 | Дунд зэрэг тохиромжтой | 3441527.5 | 2211588.5 | 806955.7 | 2294186.8 | 2294186.8 |
| 5 | Тохиромжтой | 2824014.8 | 2103660 | 294073.3 | 4270899.6 | 4270899.6 |
| Нийт талбай | | 7469019.9 | 7469019.9 | 7469019.9 | 7469019.9 | 7469019.9 |






# ГУРАВ. НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ХЭРЭГЦЭЭНД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

1. Иргэдийн хэрэгцээт байдлын үнэлгээ
2. Үйлчилгээний салбарын хэрэгцээт байдлын үнэлгээ
3. Худалдааны салбарын хэрэгцээт байдлын үнэлгээ
4. Үйлдвэрлэлийн салбарын хэрэгцээт байдлын үнэлгээ
5. Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийн хэрэгцээ
    - 5.1. Хүн, амын өсөлтийн хэтийн тооцоо:
    - 5.2. Нийгэм, дэд бүтцийн хэрэгцээ
    - 5.3. Цэцэрлэг, сургуулийн хэрэгцээ
    - 5.4. Эрүүл мэндийн байгуулгын хэрэгцээ
    - 5.5. Зах зээлийн өсөлт хэтийн төлөв
    - 5.6. Дэд бүтцийн байгуулгын хэрэгцээ
    - 5.7. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ
    - 5.8. Ажлын байрны хэрэгцээ шаардлага
    - 5.9. Байгалийн хадлан, тэжээлийн хэрэгцээ
    - 5.10. Бэлчээрийн газрын усан хангамжийн хэрэгцээ
    - 5.11. Газрын эрэлт хэрэгцээний чиг хандлага

# *Иргэдийн хэрэгцээт байдлын үнэлгээ*

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий болон сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад нутгийн иргэдийн оролцоо хамгаас чухал. Төлөвлөгөө боловсруулахдаа иргэдийн оролцоог хангаж орон нутгийн хэрэгцээт байдлын үнэлгээг гаргах үүднээс малчин, тариалан эрхлэгчид, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид, мөн зорилтод бүлгийг судалгаанд хамруулсан ба нийт 1636 санал авч ажилласан болно.

| Д/д | Сумын нэр | Иргэдийн тоо | Огноо |
|---|---|---|---|
| 1 | Адаацаг | 19/ИТТХурал/ | 2018.10.24 |
| 2 | Баянжаргалан | 35 | 2018.10.23 |
| 3 | Говь-Угтаал | 46 | 2017.09.20 |
| 4 | Гурвансайхан | 79 | 2018.10.22 |
| 5 | Дэрэн | 31 | 2018.10.23 |
| 6 | Дэлгэрцогт | 57 | 2018.10.19 |
| 7 | Дэлгэрхангай | 45 | 2018.10.26 |
| 8 | Луус | 55 | 2018.10.20 |
| 9 | Өлзийт | 43 | 2018.10.26 |
| 10 | Өндөршил | 51 | 2018.10.24 |
| 11 | Сайнцагаан | 158 | 2018.10.16-17 |
| 12 | Сайхан-Овоо | 37 | 2018.10.25 |
| 13 | Хулд | 34 | 2018.10.18 |
| 14 | Цагаандэлгэр | 29 | 2018.10.25 |
| 15 | Эрдэнэдалай | 158 | 2018.10.22 |

## Үйлчилгээний салбарын хэрэгцээт байдлын үнэлгээ

Дундговь аймгийн ДНБ-ий 33 хувийг үйлчилгээний салбарт үйлдвэрлэж байна. Сүүлийн жилүүдэд бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ, тээвэр, агуулахын аж ахуй, холбоо, санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагааны салбарт өсөлт гарч байна. Нийт дүнгээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй бүртгэгдсэн 293 гаруй аж ахуйн нэгж байгаагийн 144 нь үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

## Худалдааны салбарын хэрэгцээт байдлын үнэлгээ

2017 оны байдлаар 256 цэг салбар худалдаа эрхэлж байна. Худалдааг эрхлэх хэлбэрээр нь авч үзвэл 80.0 гаруй хувь нь жижиглэнгийн, 20.0 хувь нь бөөний худалдаа эзэлж байгаагаас харахад сүүлийн жилүүдэд бөөний цэг салбарууд бий болох эхлэл тавигдсан байна. Бараа татан авалтын 98.0 хувийг УБ хотоос татдаг. Гутал, хувцас зэрэг өргөн хэрэглээний барааны 90.0 хувийг урд хөршөөс татан авалт хийдэг байна. Худалдааны салбарт 300 орчим хүнийг ажлын байраар хангаж буй томоохон салбар юм.

## Үйлдвэрлэлийн салбарын хэрэгцээт байдлын үнэлгээ

Дундговь аймгийн статистикийн мэдээллийн санд бүртгэлтэй 613 аж ахуйн нэгж байгаагаас 396 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Харин 217 нь үйл ажиллагаа явуулаагүй буюу үйл ажиллагаагаа эхлүүлээгүй байна. Үүнээс боловсруулах үйлдвэр буюу "С" ангиллын үйлдвэр 37 байгаа ба аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2017 оны байдлаар 8097.8 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт дүнгээр 35.5 хувиар өссөн байна. Энэхүү өсөлтөд уул уурхайн олборлох аж үйлдвэр өмнөх онтой харьцуулахад 79 хувиар өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна. Мөн боловсруулах аж үйлдвэр 1.5 хувиар, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт ус хангамж 24.3 хувиар өссөн.




МУЗГ-ын "Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөрийг баталсан бол аймаг орон нутгийн эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэн ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор сумдад байгуулах 21 үйлдвэрийг тодорхойлон баталлаа.

# *Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийн хэрэгцээ*

Хүн, амын өсөлтийн хэтийн тооцоо:

Хүн амын төрөлтийн түвшин 1990 оноос эхлэн буурч ирсэн боловч 2000-иад оны дундаас тогтворжин өсөх хандлагатай байна. Тухайлбал 1990 онд төрөлт 1614 байсан бол 2017 онд 1030 болж 36,1 хувиар буурсан дүр зурагтай байна. Хүн амын хэтийн тооцооллоор төрөлт өсөх хандлагатай байгаа ч төрөх насны эмэгтэйчүүдийн тоо буурах хандлагатай байна.




| № | Насны бүлэг | 2017 он | Төлөвлөгөөний үе шат | |
|---|---|---|---|---|
| | | | Дунд үе 2021 он | Урт үе 2031 он |
| 1 | 0-14 | 13458 | 14631 | 15623 |
| 2 | 15-29 | 11799 | 10661 | 11246 |
| 3 | 30-54 | 15305 | 15215 | 13608 |
| 4 | 55-69 | 4233 | 5232 | 6609 |
| 5 | 70+ | 1588 | 1750 | 3410 |
| Нийт хүн ам | | 46383 | 47490 | 50496 |



## *Нийгэм, дэд бүтцийн хэрэгцээ*

Хүн амын хэтийн өсөлтийн тооцооллоор 2017 онд он харьцуулахад төлөвлөгөөний дунд хугацаанд 2,7 хувиар урт хугацаанд 8,9 хувиар өсөх дүр зурагтай байна. Хүн амын насны бүлэг, хүн ам зүйн ачааллаар авч үзхэд 0-15 насны хүүхэд, 65 дээш насны өндөр настны тоо өсөх хандлагатай байна.

Хүн ам зүйн ачааллын тооцохдоо хөдөлмөрийн насны 100 хүнд ноогдох тэжээгдэгчийн тоо буюу хөдөлмөрийн бус насны хүн амын нийгэмд үзүүлж буй ачааллыг хүн амын насны бүлгийн бүтцээр илэрхийлэн гаргасан. хүн ам зүйн ачаалал суурь онтой харьцуулахад 43.1 хувиар нэмэгдэх хандлагатай байна.

*Хүснэгт 32. Хүн ам зүйн ачаалал, төлөвлөгөөний дунд болон урт хугацаагаар*

| № | Төрөл | Тоогоор | | | Хүн ам зүйн ачаалал | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Суурь он /2017/ | Төлөвлөгөөний дунд хугцаа /2021/ | Төлөвлөгөөний урт хугацаа /2031/ | Суурь он /2017/ | Төлөвлөгөөний дунд хугцаа /2021/ | Төлөвлөгөөний урт хугацаа /2031/ |
| 1 | Хүүхэд /0-15/ | 14259 | 15291 | 16676 | 50.3 | 55.6 | 63.47 |
| 2 | Хөгшид /65+/ | 2397 | 2863 | 5397 | 8.5 | 10.4 | 20.54 |
| 3 | Нийт | 16656 | 18154 | 22073 | 58.7 | 66.0 | 84.01 |

## Цэцэрлэг, сургуулийн хэрэгцээ

Төлөвлөгөөний суурь оны байдлаар Дундговь аймгийн хэмжээнд төрийн өмчийн 21 хүүхдийн цэцэрлэгт 3262 хүүхэд хүмүүжиж байна. Энэ нь сургуулийн өмнөх боловсрол эзэмших хүүхдийн 80,8 хувь байна. Цэцэрлэгт хамрагдаагүй 773 хүүхэд байна. Нийт 21 цэцэрлэгийн 109 бүлэгт 104 багш ажиллаж байгаа нь нэг багшид аймгийн дунгээр 31.2 хүүхэд ноогдож байгаа нь улсын дундажаас 2.4 хүүхдээр бага байна.




*Диаграмм 16. Цэцэрлэгийн насны хүүхдийн тооны өсөлтийн хэтийн төлөв, төлөвлөгөөний дунд болон урт хугацаагаар*

Цэцэрлэгийн хэрэгцээ, төлөвлөгөөний дунд, ур хугацаагаар

| № | Сумдын нэр | Суурь он /2017/ | Төлөвлөгөөний дунд хугацаа /2021/ | Төлөвлөгөөний урт хугацаагаар /2031/ |
|---|---|---|---|---|
| 1 | Адаацаг | 1 | Өргөтгөх | |
| 2 | Баянжаргалан | 1 | | Өргөтгөх |
| 3 | Говь-Угтаал | 1 | Өргөтгөх | |
| 4 | Гурвансайхан | 1 | | |
| 5 | Дэлгэрхангай | 1 | | Өргөтгөх |
| 6 | Дэлгэрцогт | 1 | | Өргөтгөх |
| 7 | Дэрэн | 1 | | Өргөтгөх |
| 8 | Луус | 1 | Өргөтгөх | |
| 9 | Өлзийт | 1 | Өргөтгөх | |
| 10 | Сайхан-Овоо | 1 | | Өргөтгөх |
| 11 | Хулд | 1 | Өргөтгөх | |
| 12 | Цагаандэлгэр | 1 | Өргөтгөх | |
| 13 | Өндөршил | 1 | | Өргөтгөх |
| 14 | Эрдэнэдалай | 1 | Шинээр байгуулах | |
| 15 | Сайнцагаан | 7 | 2 цэцэрлэг шинээр байгуулах | 2 цэцэрлэг шинээр байгуулах |
| | Нийт | 21 | 23 | 26 |

Аймгийн хэмжээнд төлөвлөгөөний суурь оны байдлаар ерөнхий боловсролын 19 сургууль үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр сургуульд 331 бүлэгт 8084 сурагч суралцаж, 518 багш ажиллаж байна. Анги дүүргэлт нэг ангид дунджаар 24 хүүхэд суралцаж байна. Энэ нь улсын дунгээс 4,3 хүүхдээр бага байна.




Анги дүүргэлтийн дунгээс авч үзвэл Сайнцагаан, Эрдэнэдалай сумдууд 1-3 хүүхдээр их байна. Мөн аймгийн төв Сайнцагаан суманд мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 60 гаруй багш 900 орчим суралцагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

*Сургуулийн хэрэгцээ, төлөвлөгөөний дунд болон урт хугагаар,*

| № | Сумын нэр | Нэг бүлэгт сургалцаж байгаа хүүхдийн тоо /2017/ | Төлөвлөгөөний дунд хугацаа /2021/ | Төлөвлөгөөний урт хугацаагаар /2031/ |
|---|---|---|---|---|
| 1 | Эрдэнэдалай | 30 | Өргөтгөх | |
| 2 | Сайнцагаан | 28 | Шинэ сургууль байгуулах | 2 Шинэ сургууль байгуулах |

Төлөвлөгөөны дунд хугацаанд нийт сургуулийн насны хүүхдийн тоо 6.1 хувиар, урт хугацаанд 25.2 хувиар өсөх төлөвтэй байна. Нийт сургуулийн насны хүүхдийн тоо аймгийн төв Сайнцагаан суманд суралцагчдын 50 орчим хувиар өсөх хандлагатай байгаа тул төлөвлөгөөний дунд хугацаанд 1 шинэ сургууль, урт хугацаанд 2 шинэ сургууль шинээр байгуулах, Эрдэнэдалай сумын сургуулийг төлөвлөгөөний дунд хугацаанд өргөтгөх хэрэгцээтэй байна.

## *Эрүүл мэндийн байгууллагын хэрэгцээ*

Дундговь аймгийн эрүүл мэндийн статистик мэдээгээр хүн амын дундаж наслалт 2000 онд 66.5 байсан бол 2017 онд 73.58 болж 7.08 насаар нэмэгдсэн нь улсдаа хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Аймгийн хэмжээнд төр, хувийн хэвшлийн 46 байгууллага 301 ортойгоор эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байна. Төлөвлөгөөний суурь оны үзүүлэлтээр нэг эмчид 326 хүн, нэг сувилагчид 308 хүн оногдож байна. Энэ нь улсын дүнгээс 10.1-15.9 хувиар их байна. Төлөвлөгөөний дунд болон урт хугацаанд хүн амзүйн ачаалал нэмэгдэх төсөөлөлтэй байгаа тул эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын хэрэгцээ нэмэгдэнэ.






## *Зах зээлийн өсөлт хэтийн төлөв*

Дундговь аймгийн зах зээлийн өсөлтийг нэг хүнд ноогдох дотоод нийт бүтээгдэхүүнийг ашиглан 2017 оны байдлаар тооцоолход 2013 онтой харьцуулхад 158 хувиар, 2016 онтой харьцуулхад 14,3 хувиар тус тус өссөн байна. 2017 онд дотоодын нийт бүтээгдэхүүн 258.5 тэрбум төргөг, нэг хүнд ноогдох ДНБ 5.5 сая төгрөг байна. Энэ улсын дүнтэй харьцуулахад даруй 3.5 сая.төгрөгөөр бага байна. ДНБ-ний 56.4 хувийг хөдөө аж ахуйн салбар эзлэж байна




ДНБ-ны хэтийн өсөлт, 2010-2021 он, сая.төгрөг,




*Диаграмм 18. ДНБ-н салбараар, 2010-2017 он*

Үйлчилгээний салбарын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг зах зээлийн өрсөлдөөний зарчимаар хангах шаардлагатай. Үүний тулд дараах зүйлийг төлөвлөн хэрэгжүүлэх:

- Худалдаа, үйлчилгээний салбарыг тогтвортой, урт хугацаагаар үйл ажиллгаа эрхлэх тал дээр санхүү, бодлогоор дэмжих
- Аймгийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран богино хугацаатай үйлчилгээний салбарын боловсон хүчин бэлтгэх сургалтыг зохион байгуулах
- Хүн амын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээтэй уялдуулан тэлэн хөгжих хотжилтыг төлөвлөн үйлчилгээний салбарын газрыг зөв зохистой тусгах

## *Дэд бүтцийн хэрэгцээ*

Эдийн засаг, хүн амын хэтийн өсөлтөөс үндэслэн суурьшлийн бүс 2017 оны газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсанаас 18 мянган га-аар өсөх дүнтэй байна. Үүнийг суурьшлийн бүсийн функциональ бүсийн төлөвлөлтөнд тусгах шаардлагатай. Дэд бүтцгийн хэрэгцээг тооцохдоо цахилгаан дамжуулах шугам, зам, халуун хүйтэн усны шугам, ногоон байгууламжийг тооцсон.

